

**“Е МОНИЕ” ХК ХУВЬЦААТ КОМПАНИЙН
НОГДОЛ АШГИЙГ ХУВИАРЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг “Компанийн тухай” хууль, Монголын компанийн засаглалын кодекст нийцүүлэн тодорхойлоход оршино.
- 1.2. Хувьцаа эзэмшигчид нь компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг учраас өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид компанийн ашиг хуваарилалтын бодлого, ногдол ашигт хуваарилах ашгийн доод хязгаар, ашиг хуваарилах хэлбэр зэргийг тодорхой журамласан байх ёстой.
- 1.3. ТУЗ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг нийтийн хүртээл болгох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга сонирхсон бүх этгээдэд уг баримттай танилцах боломж олгохоос гадна компанийн сайтад байрлуулсан байна.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- 2.1. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 2.2. Компани дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна:
 - 2.2.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх
 - 2.2.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгөөс багагүй байх
 - 2.2.3. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн эдгээр хувьцааг бүрэн эргүүлэн авсан байх
- 2.3. Компани дараах тохиолдолд заавал ногдол ашиг хуваарилна.
 - 2.3.1. Энэ бодлогын 2.2-т заасан нөхцөл хангагдсан
 - 2.3.2. Компани ашигтай ажилласан бөгөөд компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалтад зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа.
 - 2.3.3. Компани өөрийн хөрөнгөөр худалдаж авсан халаасны хувьцаанд ногдол ашиг хувиарлахгүй.

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- 3.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 3.2. Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногын дотор ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудлыг ТУЗ-өөр хэлэлцэн шийдвэр гаргана.

- 3.3. ТУЗ-н ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.
- 3.4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- 3.5. Нийтэд хүргэж байгаа мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- 3.6. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- 4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- 4.2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт ногдол ашиг олгож эхлэх хугацааг заасан байх бөгөөд энэ хугацаандаа ногдол ашгийг олгох ёстой. Ногдол ашгийг хугацаанд нь бүрэн олгоогүй зэргээр хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл учруулсан, хохироосон тохиолдолд гүйцэтгэх захиралд хариуцлага хүлээлгэнэ.
- 4.3. Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байх нь зохимжтой. Хувьцаа эзэмшигч дансны дугаараа албан ёсоор мэдэгдсэн нөхцөлд бэлэн бусаар шилжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно.